



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 11508

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1.2 дахь хэсэг, 7.6 дахь хэсэг, "Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм"-ийн 3.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын бүрэлдэхүүнийг өөрчлөн, хавсралтаар баталсугай.

2. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, ажиллахыг комиссын дарга /Д.Төмөрбаатар/-д, татан төвлөрүүлж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч /А.Мөнгөн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/604 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000513

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2020 оны 05 дугаар сарын  
13. –ний өдрийн 0/2020 тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн  
хариуцсан комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Д.Төмөрбаатар

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

А.Мөнгөн

Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын  
үүрэг гүйцэтгэгч

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын  
хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн  
даргын үүрэг гүйцэтгэгч

С.Сэржжаргал

Өмчийн төлөөлөл, менежментийн  
хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Комиссын нарийн бичиг:

Б.Эрдэнэмөнх

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын  
хэлтсийн мэргэжилтэн